

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны.... сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журам

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам"-ыг нэгдүгээр, "Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн маяг"-ыг хоёрдугаар, "Бүртгэлийн баримт бичгийн бүрэлдэхүүн"-ийг гуравдугаар, "Бүртгэлийн гэрчилгээний загвар"-ыг дөрөвдүгээр, "Бүртгэлийн төлбөр, зардлын жишиг, зарцуулах журам"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулах, эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааны тасралгүй байдлыг ханган ажиллах, тухайн жилийн үйл ажиллагааны төлбөрийн орлогыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын төсвийн зардалд тусган батлуулж, эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, эмийн эмчилгээний идэвх, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (Л.Зэндмаа)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилт болон төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж буйд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Төгсдэлгэр)-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын "Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журам батлах тухай" 2019 оны А/295 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ийг бүртгэх журам

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Монгол Улсын урт, дунд богино хугацааны хөгжлийн бодлого, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нийцүүлэн Монгол Улсад эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх (цаашид “бүртгэл” гэх), бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах, бүртгэлийг түтгэлзүүлэх, бүртгэлээс хасах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн хэлтэс нь бүртгэлийн үйл ажиллагааны ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

1.3. Эмийн бүртгэл, бүртгэлд өөрчлөлт оруулах, хугацааг сунгах болон түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах шийдвэрийг Хүний эмийн зөвлөл (цаашид “ХЭЗ” гэх)-ийн, Оношлуурын бүртгэл, бүртгэлийн өөрчлөлт, хугацаа сунгах, бүртгэлээс хасах асуудлыг ХЭЗ-ийн Биобэлдмэл, оношлуурын салбар зөвлөл (цаашид “БОСЗ” гэх)-ийн, БИБ-ний бүртгэл, бүртгэлийн өөрчлөлт, хугацаа сунгах, бүртгэлээс хасах асуудлыг ХЭЗ-ийн Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөл (цаашид “БИБСЗ” гэх) -ийн хурлаар тус тус хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

1.4. Вакцин, биобэлдмэлийг БОСЗ-өөр хэлэлцүүлсний дараа ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

1.5. Бүртгэлийн шийдвэр гаргалтад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын итгэлцлийн зохистой дадал, Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчний эмчилгээ оношлогооны заавар, удирдамжид орсон байдал, хэрэгцээг чухалчилж, чанар, аюулгүй байдал, эмчилгээний үйлдлийн талаарх судалгааны материалд дүн шинжилгээ хийсэн шинжээчийн дүгнэлтийг үндэслэнэ.

1.6. Тушаалын 1.3, 1.4-т заасан зөвлөлөөс бүртгэх шийдвэр гаргасан тухайн шошго бүхий савлалтын хэлбэрийг бүртгэлтэйд тооцох бөгөөд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй, өөр хаяглалт, савлалттай бол бүртгэлгүйд тооцно.

1.7. Эм, эмийн түүхий эд, оношлуурын хувьд бүртгүүлэх хүсэлт гаргагч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол Улсын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, биологийн идэвхт бүтээгдэхүүний хувьд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, тухайн үйлдвэрлэгчийг Монгол Улс төлөөлөх албан ёсны төлөөлөгчийн газар (цаашид “бүртгүүлэгч” гэх) байна.

1.8. Эмийн бүртгэлийн хэлтэс нь бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, баримт бичгийг бүрэн бүтэн байдлыг хангаж, хадгаламжийн нэгж, бүртгэлийн мэдээний санг тогтмол баяжуулж, оролцогч талуудыг бодит мэдээллээр хангаж ажиллана.

Хоёр. Бүртгэлийн бодлого, зарчим

2.1. Импортын эм, БИБ нь үйлдвэрлэгч улсынхаа эмийн бүртгэлд бүртгэгдээд, тухайн улсын зах зээлд 3-аас доошгүй жил хэрэглэсэн байна.

2.2. Импортын эм нь бусад 5-аас доошгүй улсад бүртгэгдсэн эсхүл ДЭМБ-ын жишиг тогтоох үнэлгээгээр 3 болон түүнээс дээш төлөвшлийн түвшинтэй үнэлэгдсэн эрх бүхий байгууллагатай улсад бүртгэгдсэн байна.

2.3. ДЭМБ-ын урьдчилсан баталгаажуулалтад орсон, ДЭМБ-ын жишиг тогтоох үнэлгээгээр 3 болон түүнээс дээш төлөвшлийн түвшинтэй үнэлэгдсэн эрх бүхий байгууллага нь тухайн улсдаа зах зээлд гаргах зөвшөөрөл олгосон жороор олгох эм, оношлуурыг түргэвчилсэн хэлбэрээр бүртгэнэ.(цаашид “түргэвчилсэн” бүртгэл гэх).

2.4. ДЭМБ-ын жишиг тогтоох үнэлгээгээр 3 болон түүнээс дээш төлөвшлийн түвшинтэй үнэлэгдсэн улсын эрх бүхий байгууллагын талаарх мэдээллийг ДЭМБ-ын албан ёсны цахим хуудаснаас авна. <https://www.who.int/publications/m/item/list-of-who-listed-authorities-wlas>

2.5. Яаралтай тусламж, эрчимт эмчилгээнд хэрэглэх, өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаант өвчний эмнэлзүйн удирамжид үндэслэн гаргасан тухайн жилд нэн тэргүүнд бүртгэх шаардлагатай эмийн жагсаалт, үндэсний Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон боловч, эмийн бүртгэлд бүртгэгдээгүй болон 3-аас доош үйлдвэрлэгчээс бүртгэлтэй, нөөц тасрах эрсдэлтэй, бүртгэлтэй боловч зах зээлд нийлүүлэгдэхгүй, орлуулах эм байхгүйгээс эмчилгээ үйлчилгээ тасалдах эмийг нөхцөлт бүртгэлд хамруулна.

2.6. Нөхцөлт бүртгэлийн тусгай шалгуурыг ХЭЗ тухай бүрт батална. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар шалгуур боловсруулах стандарт ажиллагааны зааврыг батлан хэрэгжүүлнэ.

2.7. Бүртгүүлэх эм, эмийн түүхий эд, БИБ-ийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн байна. /Түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй/

2.8. Бүртгүүлэх вакцин, сүрьеэгийн эм ДЭМБ-ын урьдчилсан баталгаажуулалт хамрагдсан байна.

2.9. Хүүхдийн эмийн хувьд хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл болон бусад холбогдох салбар зөвлөлийн дүгнэлт саналыг үндэслэн насны онцлогт нь тохирсон тун, хэлбэр, савлалттай байх ба хүүхдэд харшлах түүхий эд, туслах бодис ороогүй болохыг нотолсон байна.

2.10. Монгол Улсын эмчилгээ, оношилгоонд шинээр нэвтэрч буй эм, биобэлдмэл, эмчилгээнд шинэ заалтаар хэрэглэж байгаа эм, биобэлдмэлийг холбогдох мэргэжлийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн бүртгэнэ.

2.11. Шинэ эмийг бүртгэлийн баримт бичиг нь “International Council for Harmonization (ICH)” удирдамжийн шаардлага хангасан байна.

2.12. Уламжлалт эмийг бүртгүүлэхэд уламжлалт жор болохыг нотлох жорын эх сурвалжийн талаарх мэдээллийг ирүүлнэ.

2.13. Уламжлалт жорыг орчин үеийн эмийн хэлбэрт оруулсан үндэсний үйлдвэрийн эмийн шошгонд худалдааны нэршлээс гадна үндсэн уламжлалт жорын нэршлийг бичнэ.

2.14. Нэг үйлдвэрлэгчийн ижил үндсэн үйлчлэгч бодис, тун хэмжээ, хэлбэр бүхий эмийг хоёр өөр худалдааны нэрээр бүртгэхгүй.

2.15. Нэг худалдааны нэртэй эмийг хоёр өөр үйлдвэрлэгчээс бүртгэхгүй.

2.16. Бүртгүүлэх БИБ нь генетикийн өөрчлөлтөд орсон орц ашиглаагүй байна.

2.17. Бүртгүүлэх БИБ-ий ангилалын жагсаалтыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалын газрын даргын тушаалаар батална.

2.18. Оношлуурын бүртгэлийн баримт бичиг нь “Global harmonization task force” удирдамжийн шаардлага хангасан байна.

2.19. Бүртгэлийн шийдвэртэй холбоотой маргаан үүсэх тохиолдолд нарийн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн санал дүгнэлтэд тулгуурлан маргааныг шийдвэрлүүлнэ.

Гурав. Бүртгэлд тавигдах ерөнхий тавигдах шалгуур

3.1. ХЭЗ, салбар зөвлөл нь бүртгэлийн асуудлаар шийдвэр гаргахдаа дараах мэдээллийг үндсэн шалгуур болгоно.

3.1.1. Эм, эмийн түүхий эд үйлдвэрлэгч нь Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын шаардлага, оношлуур, БИБ үйлдвэрлэгч нь Чанарын удирдлагын тогтолцоо (ISO) шаардлага хангасан эсэх;

3.1.2. Хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн шинжилгээний дүн;

3.1.3. Бүртгэлийн шинжээчийн дүгнэлт;

3.1.4. Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн байдал, хангамж, хүртээмж, хэрэгцээ, үнэ;

3.1.5. Нийлмэл найрлагатай эм нь дан найрлагатай эмээс эмчилгээний үйлдэлээр илүү, аюулгүй болохыг судалгаагаар нотолсон байх;

3.1.6. Ерөнхий нэршлийн эмийн биохүрэхүйн судалгааны дүн;

3.1.7. Зарим улсын эмийн бүртгэлээс тухайн эм болон үндсэн үйлчлэгч бодисыг хэрэглэхийг хориглосон буюу нас болон тунгийн хязгаартай хэрэглэх шийдвэр гаргаж байсан эсэх;

3.1.8. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид “ДЭМБ” гэх)-аас сэрэмжлүүлсэн эмийн жагсаалтад орсон эсэх;

3.1.9. Тухайн эм, оношлуур, БИБ-ийг зах зээлд гаргах талаар үйлдвэрлэсэн улс болон тухайн эмийг бүртгэсэн улсын эрх бүхий байгууллагын шийдвэр;

3.1.10. Шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт, санал

3.2. Бүртгэлийн баримт бичиг нь Монгол, Англи, Орос хэлний аль нэг дээр байна.

3.3. Бусад хэл дээрх баримт бичгийг Монгол хэлээр орчуулсан баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.

3.4. Бүртгүүлэх эм нь хоёрдогч савлалт дээрх хаяглалт тэмдэглэгээ нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгтэй нийцсэн, олон улсын стандарт шаардлагад нийцсэн зураасан кодтой, хаяглалт нь Монгол, Англи, Орос хэлний аль нэг дээр дагнасан эсхүл нэмэлт нэг улсын хэлтэй хосолсон байж болно. /Зөвхөн бүртгэлийн загвар дээжийн хаяглалт, савлалт нь наалт хэлбэртэй байж болно./

3.5. Эмийн хэрэглэх заавар нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заагдсан мэдээллийг агуулсан, Монгол хэлээр бичигдсэн байна.

Дөрөв. Бүртгүүлэх эм, оношлуур, БИБ-нд тавигдах шаардлага

4.1. Улсын бүртгэлд бүртгүүлэх эм нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.1.1. Лиценз эзэмшигч нэг байхаас үл хамаарч эмийн эцсийн бүтээгдэхүүн тус бүрийн үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP)-ын, оношлуур үйлдвэрлэгч нь Чанарын удирдлагын тогтолцоо (ISO 13485)-ны, биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нь “Эм үйлдвэрлэлийн зохистой дадал” (GMP) эсхүл “Чанарын удирдлагын тогтолцоо”, “Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо”, “Хүнсний үйлдвэрлэлийн аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын хяналт” (ISO 9001, ISO 22000, ISO 17025:2018, HACCP), тухайн орны ижил төрлийн стандартын шаардлага хангасан байх;

4.1.2. Үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигч (цаашид “үйлдвэрлэгч” гэх) улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний гэрчилгээтэй байх;

4.1.3. Эмийн чанар, аюулгүй байдал, эмчилгээний үйлдэл, найрлага, тун, тогтвортой байдал нь шинжлэх ухааны туршилт судалгаагаар нарийвчлан тогтоогдсон;

4.1.4. Эмчилгээний үйлдэл, аюулгүй байдал нь эмнэлзүйн өмнөх ба эмнэлзүйн судалгаагаар тогтоогдсон;

4.1.5. Эмийн хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, эмийн харилцан үйлчлэл, тунгийн хязгаар нь эмнэлзүйн туршилтаар бүрэн нотлогдсон

4.1.6. Эмнэлгийн мэргэжилтэнд болон үйлчлүүлэгчид зорилсан мэдээлэл хэрэглэх заавар, шошго нь нотолгоонд суурилсан, хараат бус, үнэн зөв байна.

4.1.7. Вакцин нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон цувралын баталгаажилтын гэрчилгээ (lot release)-тэй байна.

4.1.8. Бүртгүүлэх мансууруулах, сэтгэц нөлөөт үйлдэлтэй эм нь 1961, 1971 оны олон улсын конвенцийн жагсаалт болон Монгол Улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх мансууруулах, сэтгэц нөлөөт үйлдэлтэй эмийн жагсаалтад орсон байх;

4.1.9. Ерөнхий нэршлийн эмэнд биохүрэхүйн судалгаа хийгдсэн байх.

Тав. Бүртгэлийн үйл ажиллагаа

5.1. Тухайн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ий бүртгэлтэй холбоотой дараах үйл ажиллагааг “Ажлын алба” зохион байгуулна. Үүнд:

5.1.1. Үйлдвэрлэгчээс баталгаажуулж ирүүлсэн бүртгэлийн баримт бичгийг шалгаж хүлээн авах;

5.1.2. Гэрээ байгуулсан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээх;

5.1.3. Бүртгэлийн шинжээчийн дүгнэлт гаргуулах;

5.1.4. Шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн байгууллага, ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн дүгнэлт, санал гаргуулах;

5.1.5. Бүртгэлийн асуудлыг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

5.1.6. Маргаантай тохиолдолд ХЭЗ-өөс шинжээчдийн баг, ажлын хэсгийг томилуулан дүгнэлт гаргуулах;

5.1.7. Бүртгэлийн баримт бичгийн хадгаламжийн нэгжийг цаасан болон цахим хэлбэрээр авах;

5.1.8. Нэн тэргүүнд бүртгэх эмийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүртээмжийн судалгааг эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллага, бүртгүүлэгч байгууллага, судлаачдын багтай хамтран хийх;

5.2. Ажлын алба нь бүртгэлийн үйл ажиллагааны чиглэл бүрээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргаар батлуулсан стандарт ажиллагааны зааврыг мөрдөнө.

5.3. Бүртгэлийн баримт бичгийг цаасаар болон Төрийн цахим систем (E-Mongolia)-ээр хүлээн авна.

5.4. Бүртгүүлсэн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ийн мэдээллийг Licemed цахим системээр авч мэдээний сан үүсгэнэ.

5.5. Ажлын албанаас бүртгүүлэгч байгууллагуудад Licemed цахим системд нэвтрэх эрхийг олгоно.

5.6. Бүртгүүлэгч нь бүртгүүлэх эмийн дараах мэдээллийг Licemed цахим системд ирүүлнэ. Үүнд:

- 5.6.1. Эмийн худалдааны нэр;
- 5.6.2. Олон улсын нэршил;
- 5.6.3. Найрлага (үндсэн болон туслах бодисууд);
- 5.6.4. Тун хэмжээ;
- 5.6.5. Эмийн хэлбэр;
- 5.6.6. Хүний анатомийн бүтцэд суурилсан ангилал (АТС);
- 5.6.7. Эм судлалын ангилал;
- 5.6.8. Бар код;
- 5.6.9. Өртөг шингэсэн бөөний үнэ (үндэсний үйлдвэрлэгчийн хувьд агуулахын үнэ);
- 5.6.10. Үйлдвэрлэгчийн нэр;
- 5.6.11. Үйлдвэрлэсэн улсын нэр;
- 5.6.12. Лиценз эзэмшигчийн нэр;
- 5.6.13. Эмийн бүтээгдэхүүний тодорхойлолт;
- 5.6.14. Баталгаажуулсан хэрэглэх заавар;
- 5.6.15. Зураг;
- 5.6.16. Бар код эсхүл зураасан код.

5.7. Бүртгүүлэгч нь бүртгүүлэх эмийн түүхий эдийн дараах мэдээллийг Licemed цахим системд ирүүлнэ. Үүнд:

- 5.7.1. Худалдааны нэр;
- 5.7.2. Олон улсын нэршил;
- 5.7.3. Өртөг шингэсэн бөөний үнэ (үндэсний үйлдвэрлэгчийн хувьд агуулахын үнэ);
- 5.7.4. Үйлдвэрлэгчийн нэр;
- 5.7.5. Үйлдвэрлэсэн улсын нэр;
- 5.7.6. Лиценз эзэмшигчийн нэр;
- 5.7.7. Зураг.
- 5.7.8. Бар код эсхүл зураасан код.

5.8. Бүртгүүлэгч нь бүртгүүлэх оношлуурын дараах мэдээллийг Licemed цахим системд ирүүлнэ. Үүнд:

- 5.8.1. Оношлуурын нэр;
- 5.8.2. Каталогийн дугаар;
- 5.8.3. Шинжилгээний төрөл;
- 5.8.4. Оношлуурын арга;
- 5.8.5. Савлалт;
- 5.8.6. Өртөг шингэсэн бөөний үнэ (үндэсний үйлдвэрлэгчийн хувьд агуулахын үнэ);
- 5.8.7. Үйлдвэрлэгчийн нэр;
- 5.8.8. Үйлдвэрлэсэн улсын нэр;
- 5.8.9. Тухайн оношлуурыг хэрэглэх заалт;
- 5.8.10. Баталгаажуулсан хэрэглэх заавар;
- 5.8.10. Өвөрмөц, мэдрэг чанар;

5.8.11. Зураг.

5.9. Бүртгүүлэгч нь бүртгүүлэх БИБ-ий дараах мэдээллийг Licemed цахим системд ирүүлнэ. Үүнд:

- 5.9.1. БИБ-ний нэр;
- 5.9.2. Найрлага (үндсэн болон туслах бодисууд);
- 5.9.3. Тун хэмжээ;
- 5.9.4. Хэлбэр;
- 5.9.5. Өртөг шингэсэн бөөний үнэ (үндэсний үйлдвэрлэгчийн хувьд агуулахын үнэ);
- 5.9.6. Үйлдвэрлэгчийн нэр;
- 5.9.7. Үйлдвэрлэсэн улсын нэр;
- 5.9.8. Тухайн БИБ-нийг хэрэглэдэг улсын нэрс;
- 5.9.10. Баталгаажуулсан хэрэглэх заавар;
- 5.9.11. Зураг;
- 5.9.12. Бар код эсхүл зураасан код.

5.10. Үйлдвэрлэгчээс ирүүлсэн бүртгэлийн баримт бичгийн үнэн зөв, бодит байдлыг бүртгүүлэгч тал бүрэн хариуцна.

5.11. Тухайн бүтээгдэхүүний шинжилгээнд онцлогоор хэрэглэгдэх стандарт бодис, урвалж, материал хэрэгслийг бүртгүүлэгч тал хариуцан итгэмжлэгдсэн лабораторид хүлээлгэн өгнө.

5.12. Тухайн бүртгүүлэхээр хүсэлт гаргасан болон бүртгэлийн дараах тандалт судалгааны явцад тухайн эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах тохиолдолд гарах зардлыг үйлдвэрлэгч эсхүл бүртгүүлэгч тал бүрэн хариуцна.

5.13. Эмийг бүртгэх шийдвэрт олон улсын болон худалдааны нэр, хэлбэр, тун хэмжээ, савлалтын хэмжээ, олгох нөхцөл, бүртгэлийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улс, лиценз эзэмшигчийг заана.

5.14. Оношлуурыг бүртгэх шийдвэрт оношлуурын нэр, каталогийн дугаар, шинжилгээний төрөл, савлалтын хэмжээ, бүртгэлийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улсыг заана.

5.15. БИБ-ийг бүртгэх шийдвэрт бүтээгдэхүүний нэр, хэлбэр, тун, савлалтын хэмжээ, бүртгэлийн хүчинтэй хугацаа, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн улсыг заана.

5.16. Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ийг 5 жилийн хугацаагаар бүртгэж, гэрчилгээ олгоно.

5.17. Бүртгүүлэгч нь хоёрдугаар хавсралтад заасан эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ бүртгүүлэх өргөдлийн маягтыг бөглөж, тухайн үйлдвэрлэгчийн эрх бүхий этгээд баталгаажуулсан, холбогдох баримт бичгүүд, эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт, зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөөг албан бичгийн хамт ажлын албанд цаасаар болон цахимаар ирүүлнэ.

5.18. Бүртгүүлэгч нь “Архивын баримт ашиглах, лавлагаа хуулбар олгох” журмын дагуу бүртгэлийн баримт бичгийн хадгаламжийн нэгж, эмийн анхдагч, хоёрдогч савлалтын зургийг хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт цахим хэлбэрээр ажлын албанд хүлээлгэж өгнө.

5.19. Эмийн хэрэглэх зааврыг бүртгэхээс өмнө Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулсны дараа эмийг бүртгүүлэх хүсэлтийг ирүүлнэ. Бүртгэсэн эмийг зах зээлд нэвтрүүлэхдээ баталгаажсан хэрэглэх зааврыг хавсарган түгээнэ.

5.20. БИБ-ний хэрэглэх зааврыг БИБ-ний шинжээчээр хянуулсны дараа бүртгүүлэх хүсэлтийг ирүүлнэ. Бүртгэсэн БИБ-нийг зах зээлд нэвтрүүлэхдээ баталгаажсан хэрэглэх зааврыг хавсарган түгээнэ.

5.21. Шаардлагатай тохиолдолд ажлын алба нь үйлдвэрлэгчээс ирүүлсэн баримт бичгийн талаар тухайн улсын эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодруулга авах ба гарах зардлыг бүртгүүлэгч тал хариуцна.

5.22. Ажлын алба нь бүртгэлийн баримт бичгийг хүлээн авахдаа тухайн эмийг үйлдвэрлэгчээс баталгаажуулсан өргөдлийг хүчинтэй гэж үзэх бөгөөд факс, цахилгаан шуудангаар илгээсэн баримт бичгийг шаардлага хангахгүйд тооцно.

5.23. ХЭЗ-ийн хурлаас эмнэлзүйн ажиглалт хийх шийдвэр гаргасан тохиолдолд ажиглалт хийх эмнэлэг, хамруулах хүний тоог нарийн тогтооно. Ажиглалтын дүнг ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, эмийн бүртгэлийг шийдвэрлүүлнэ.

5.24. Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний бүртгэлийн явцад энэхүү журмын 5.1.2-д заасан лабораторийн шинжилгээгээр шаардлага хангаагүй тохиолдолд тухайн бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг зогсоож, шаардлага хангаагүй бүтээгдэхүүний мэдээний санд бүртгэж, ХЭЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулна.

5.25. Бүртгэлийн үйл ажиллагаа дараах үе шаттайгаар, дор дурдсан хугацаанд хэрэгжинэ. Үүнд:

Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
Бүртгэлийн баримт бичигт анхдагч дүн шинжилгээ хийх	Бүртгэлийн баримт бичигт бүрэн хүлээж авснаас хойш ажлын 5 хоногт	Эмийн бүртгэлийн хэлтэс
Бүртгэлийн хураамж нэхэмжлэх, төлбөр барагдуулах	Анхдагч дүн шинжилгээ хийснээс хойш ажлын 5 хоног дотор	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгүүлэгч
Лабораторийн шинжилгээнд хамруулах (түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй)	Бүртгэлийн баримт бичиг бүрэн хүлээж авснаас 1 сарын дотор	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгүүлэгч
Бүртгэлийн шинжээчийн дүгнэлт гаргах	Лабораторийн шинжилгээний дүн гарсны дараа (тус бүр 1 сарын дотор)	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгэлийн шинжээч
ХЭЗ, БОСЗ, БИБ-ний салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Шинжээчийн дүгнэлт гарснаас хойш 1 сарын дотор	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгэлийн шинжээч
Хурлын шийдвэрийг хүргүүлэх	Хурлын тэмдэглэл эцэслэн гарснаас хойш ажлын 5 хоногт	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгүүлэгч
Хурлаас түдгэлзүүлж хойшлуулсан тохиолдолд бүртгэлийг дахин хэлэлцүүлэх	2 сарын дотор	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгүүлэгч
Бүртгүүлэгч байгууллагын "Licemed" цахим системд илгээсэн хүсэлтийг ХЭЗ, БОСЗ, БИБСЗ-ийн хурлын тэмдэглэлийг үндэслэн баталгаажуулах	Бүртгэлийн гэрчилгээ бичсэнээс хойш ажлын 5 хоногт	Эмийн бүртгэлийн хэлтэс, Бүртгүүлэгч
Бүртгэлийн гэрчилгээ олгох	Бүртгэлийн гэрчилгээ бичсэнээс хойш ажлын 5 хоногт	Эмийн бүртгэлийн хэлтэс

5.26. Импортын эмийн түргэвчилсэн болон энгийн бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.26.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
- 5.26.2. Үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигчээс ирүүлсэн албан хүсэлт;
- 5.26.3. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 5.26.4. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 5.26.5. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдөл;
- 5.26.6. Бүртгүүлэгч нь тухайн үйлдвэрлэгчтэй байгуулсан эм бүртгүүлэх гэрээний хуулбар хувь;
- 5.26.7. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 5.26.8. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь (ДЭМБ-ын жишгийн дагуу ба эмийн бүтээгдэхүүний тодорхойлолтыг хавсаргасан байх);
- 5.26.9. Үйлдвэрлэгч улсдаа бүртгэгдсэн бүртгэлийн гэрчилгээний хуулбар (бүртгэл нь хүчинтэй, хугацаа дуусаагүй гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх);
- 5.26.10. ДЭМБ-ын жишиг тогтоох үнэлгээгээр төлөвшлийн түвшин 3 ба түүнээс дээш үнэлэгдсэн эрх бүхий байгууллагатай улсад бүртгэгдсэн эсхүл бусад 5 улсад бүртгэгдсэн байдал (гадаадын улсад бүртгэгдсэн, бүртгэл нь хүчинтэй, хугацаа дуусаагүй гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх);
- 5.26.11. Үйлдвэрийн танилцуулга (үйлдвэрлэлий процессыг тусгасан, монгол хэлээр орчуулж ирүүлэх);
- 5.26.12. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дүн / үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хувь,
- 5.26.13. Эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дэлгэрэнгүй аргачлал;
- 5.26.14. Үйлдвэрлэгчийн үндсэн үйлчлэгч болон туслах бодисыг шинжилсэн шинжилгээний дүн;
- 5.26.15. Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын судалгааны дүн;
- 5.26.16. Бүтэн цувралыг хамруулсан үйлдвэрлэлийн ажиллагааны заавар, үйлдвэрлэлийн процесс, схем (дамжлага дундын хяналтыг оруулах), вакцины хувьд нийт цувралын тэмдэглэл (summary lot protocol);
- 5.26.17. Ерөнхий нэршлийн эмийн хувьд биохүрэхүйн чанарыг тогтоосон судалгааны дүн (ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу шаардлагатай эмийн хэлбэрт хийсэн судалгаа);
- 5.26.18. Вакцины хувьд олон улсад зөвшөөрөгдсөн лабораторийн шинжилгээний дүн болон тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон цувралыг чөлөөлсөн сертификат эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон түүнтэй дүйцэхүйц баримт бичгийн баталгаажсан хувь;
- 5.26.19. Эмийн хорон чанар (ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй), идэвх, аюулгүй байдлыг судалсан судалгааны дүгнэлт;
- 5.26.20. Нийлмэл найрлагатай эмийн хувьд дан найрлагатай эмээс үйлдлийн идэвхээр илүү, аюулгүй болохыг тогтоосон судалгааны дүн;
- 5.26.21. Эмийн гадаад хэрэглэх заавар, Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан Монгол хувийн хамт;
- 5.26.22. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг, загвар дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);
- 5.26.23. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн (энэ заалт түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй).
- 5.26.24. Бүртгүүлэх эмийн үнийг дотоодын бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулсан судалгаа;
- 5.26.25. Бүртгүүлэгч байгууллагаас үндэсний үйлдвэрт үйлдвэрлэдэг эмэнд хийсэн зах зээлийн эрэлт хэрэгцээ, хүртээмжийн судалгаа;
- 5.26.26. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

5.27. Нэн тэргүүнд бүртгэх эмийг бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

5.27.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;

5.27.2. Үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигчээс ирүүлсэн албан хүсэлт /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;

5.27.3. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;

5.27.4. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;

5.27.5. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдөл /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;

5.27.6. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);

5.27.7. Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь эсхүл чөлөөт худалдааны гэрчилгээ;

5.27.8. Үйлдвэрлэгч улсдаа бүртгэгдсэн бүртгэлийн гэрчилгээний хуулбар (бүртгэл нь хүчинтэй, хугацаа дуусаагүй гэрчилгээний хуулбарыг үйлдвэрлэгч эсхүл лиценз эзэмшигчийн тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлэх);

5.27.9. Үйлдвэрийн танилцуулга (үйлдвэрлэлийн процессыг тусгасан, монгол хэлээр орчуулж ирүүлэх);

5.27.10. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дүн /үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хувь,

5.27.11. Эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дэлгэрэнгүй аргачлал;

5.27.12. Үйлдвэрлэгчийн үндсэн үйлчлэгч болон туслах бодисыг шинжилсэн шинжилгээний дүн;

5.27.13. Бүтээгдэхүүний хадгалах хугацааг баталсан тогтвортой чанарын судалгааны дүн;

5.27.14. Ерөнхий нэршлийн эмийн хувьд биохүрэхүйн чанарыг тогтоосон судалгааны дүн (ДЭМБ-ийн зөвлөмжийн дагуу шаардлагатай эмийн хэлбэрт хийсэн судалгаа);

5.27.15. Эмийн хорон чанар (ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй), идэвх, аюулгүй байдлыг судалсан судалгааны дүгнэлт;

5.27.16. Эмийн гадаад хэрэглэх заавар, Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан Монгол хувийн хамт;

5.27.17. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг, загвар дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);

5.27.18. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн (энэ заалт түргэвчилсэн бүртгэлд хамаарахгүй);

5.27.19. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт.

5.28. Үндэсний үйлдвэрийн эмийн бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

5.28.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;

5.28.2. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;

5.28.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;

5.28.4. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдөл /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;

5.28.5. Эрх бүхий эмийн бүртгэлийн хэлтэснаас баталгаажуулсан оюуны өмчийн гэрчилгээний хуулбар (хэрэв байгаа бол);

5.28.6. Генетикийн нөөц ашигласан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн батлгаажуулсан хуулбар;

5.28.7. Үйлдвэрийн танилцуулга;

5.28.8. Эм үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.28.9. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);

- 5.28.10. Фармакопейн хороогоор батлуулсан, хүчинтэй хугацаатай фармакопейн өгүүлэлийн баталгаажсан хуулбар (тухайн эм МУ-ын ҮФ-д ороогүй тохиолдолд);
- 5.28.11. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
- 5.28.12. Үндсэн үйлчлэгч болон туслах бодисыг шинжилсэн үйлдвэрлэгч (гадны болон дотоодын)-ийн шинжилгээний дүн;
- 5.28.13. Эмийн тогтвортой чанарын судалгааны дүн;
- 5.28.14. Эмийн фармакологи үйлдэл, идэвхийг эмнэлзүйн өмнөх болон эмнэлзүйн судалгаагаар судалсан дүн (ерөнхий нэршлийн эмэнд хамаарахгүй);
- 5.28.15. Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан хэрэглэх заавар;
- 5.28.16. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт зураг, загвар дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);
- 5.28.17. Бүртгүүлэх эмийн үнийг бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулсан судалгаа;
- 5.28.18. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

- 5.29. Импортын уламжлалт эмийн бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:
- 5.29.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;
 - 5.29.2. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
 - 5.29.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
 - 5.29.4. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
 - 5.29.5. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
 - 5.29.6. Тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь (ДЭМБ-ын жишгийн дагуу);
 - 5.29.7. Үйлдвэрийн танилцуулга (цаасан болон медиа хэлбэрээр);
 - 5.29.8. Бүтээгдэхүүний тодорхойлолт, хэрэглэх заалт, бусад эм болон эмийн хэлбэртэй харилцан нөлөөлөх нөлөөлөл, гаж нөлөөний талаарх мэдээлэл;
 - 5.29.9. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дүн (эх хувь), шинжилгээний аргачлал;
 - 5.29.10. Орц найрлагад орсон түүхий эдийн гарал үүсэл, шинжилгээний дүн;
 - 5.29.11. Тогтвортой чанарын судалгааны дүн;
 - 5.29.12. Эмнэлзүйн өмнөх (амьтанд хийсэн цочмог ба архаг хоруу чанар, гаж нөлөө, үр хөврөлд үзүүлэх нөлөө болон мутац, хавдар үүсгэх нөлөө), эмнэлзүйн үр нөлөө, аюулгүй байдал (эмнэлзүйн I, II шатны судалгааны үр дүн, илэрсэн гаж нөлөө)-ын судалгааны дүн;
 - 5.29.13. Уламжлалт жор болохыг нотлох жорын эх сурвалжийн талаарх мэдээлэл;
 - 5.29.14. Эмийн гадаад хэрэглэх заавар, Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан Монгол хувийн хамт;
 - 5.29.15. Эмийн анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг, загвар дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);
 - 5.29.16. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
 - 5.29.17. Бүртгүүлэх эмийн үнийг дотоодын бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулсан судалгаа;
 - 5.29.18. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

- 4.30. Үндэсний үйлдвэрийн уламжлалт эмийн бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.30.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт /эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулсан/;
- 5.30.2. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 5.30.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 5.30.4. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;

5.30.5. Генетикийн нөөц ашигласан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн баталгаажуулсан хуулбар;
5.30.6. Үйлдвэрийн танилцуулга (цаасан болон медиа хэлбэрээр);
5.30.7. Эм үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
5.30.8. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
5.30.9. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн шинжилгээний дүн;
5.30.10. Эмэнд орсон түүхий эдийн гарал үүслийн бичиг, шинжилгээний дүн;
5.30.11. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
5.30.12. Шинээр зохион бүтээсэн эмийн хувьд эмнэлзүйн өмнөх (амьтанд хийсэн цочмог ба архаг хоруу чанар, гаж нөлөө, үр хөврөлд үзүүлэх нөлөө болон мутац, хавдар үүсгэх нөлөө), эмнэлзүйн үр нөлөө ба аюулгүй байдал (эмнэлзүйн I, II шатны судалгааны үр дүн ба илэрсэн гаж нөлөө)-ын судалгааны дүн;
5.30.13. Уламжлалт жор болохыг нотлох жорын эх сурвалжийн талаарх мэдээлэл;
5.30.14. Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан хэрэглэх заавар;
5.30.15. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт зураг, загвар, дээж (Эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх);
5.30.16. Бүртгүүлэх эмийн үнийг бөөний болон жижиглэнгийн үнэтэй харьцуулсан судалгаа;
5.30.17. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

5.31. Эмийн түүхий эдийн бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

5.31.1. Эм бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
5.31.2. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
5.31.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
5.31.4. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
5.31.5. Үйлдвэрийн танилцуулга;
5.31.6. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
5.31.7. Мал, амьтан, ургамал, эрдэс, байгалийн гаралтай түүхий эд бол гарал үүслийн бичиг, тодорхойлолт;
5.31.8. Түүхий эдийг шинжилсэн үйлдвэрлэгчийн лабораторийн шинжилгээний дүнгийн эх хувь;
5.31.9. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
5.31.10. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг;
5.31.11. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

4.32. Импортын оношлуурын бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

5.32.1. Оношлуур бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
5.32.2. Хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
5.32.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
5.32.4. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
5.32.5. Үйлдвэрийн танилцуулга;
5.32.6. Үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ (ISO13485)-ний хуулбар (үйлдвэрлэгч баталгаажуулсан байх);
5.32.7. Гарал үүслийн улсдаа “оношлуур” гэсэн ангилалд орсныг тодорхойлох баримт;
5.32.8. Оношлуурын ерөнхий тодорхойлолт, өвөрмөц үзүүлэлтүүд;
5.32.9. Оношлуурыг шинжилсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, загвар дээжийг туршсан дүнгүүд;
5.32.10. Шинжилгээний эрсдэл болон хяналтын талаарх дүгнэлт;
5.32.11. Оношлуурын үйлдвэрлэл болон загвартай хамааралтай техникийн баримт болон баталгаажуулалт;

- 5.32.12. Эмнэлзүйн үнэлгээ, судалгааны дүн;
- 5.32.13. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан хэрэглэх заавар, БОСЗ-өөр баталгаажуулсан Монгол хувийн хамт;
- 5.32.14. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт зураг, загвар дээж;
- 5.32.15. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

5.33. Үндэсний үйлдвэрийн оношлуурын бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.33.1. Оношлуур бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
- 5.33.2. Хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 5.33.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 5.33.4. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
- 5.33.5. Үйлдвэрлэл явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- 5.33.6. Үйлдвэрийн танилцуулга (цаасан болон электрон хэлбэрээр);
- 5.33.7. Бүтээгдэхүүний орц, найрлага, аюулгүй байдлын үзүүлэлтүүд;
- 5.33.8. Шаардлагатай тохиолдолд оношлуурын өвөрмөц, мэдрэг чанарын үзүүлэлт;
- 5.33.9. БОСЗ-өөр баталгаажуулсан Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан хэрэглэх заавар;
- 5.33.10. Оношлуурын өвөрмөц, мэдрэг чанарын үзүүлэлтийн талаар холбогдох мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлт;
- 5.33.11. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт зураг, загвар дээж;
- 5.33.12. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

5.34. Импортын БИБ-ний бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 5.34.1. БИБ бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
- 5.34.2. Хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 5.34.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 5.34.4. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
- 5.34.5. Үйлдвэрийн танилцуулга (цаасан болон электрон хэлбэрээр);
- 5.34.6. Бүртгүүлэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 5.34.7. Үйлдвэрлэгч нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) эсхүл “Чанарын удирдлагын тогтолцоо”, “Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо”, “Хүнсний үйлдвэрлэлийн аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын хяналт” (ISO:9001, ISO:22000, ISO17025:2018, HACCP)-ыг нэвтрүүлсэн гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 5.34.8. Тухайн БИБ-ний экспортын зөвшөөрөл эсхүл чөлөөт худалдааны гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 5.34.9. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн лабораторийн шинжилгээний дүнгийн эх хувь;
- 5.34.10. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
- 5.34.11. Бүтээгдэхүүний орц, найрлага, аюулгүй байдлын үзүүлэлтүүд, үйлчлэл, сөрөг нөлөөний талаарх болон шинжилгээний арга, аргачлал;
- 5.34.12. Генетикийн өөрчлөлтөд орсон орц ашигласан эсэх талаар үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
- 5.34.13. Тухайн бүтээгдэхүүний найрлагад амьд бичил биетэн орсон бол бичил биетний овог, төрлийг латин нэрээр тодорхой заасан бүтээгдэхүүний патентын талаарх үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
- 5.34.14. Сэргээшийн бүлэгт багтдаг орцыг ашиглаагүй тухай үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
- 5.34.15. Түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ, тэдгээрийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан баримт;
- 5.34.16. Гадаад хэрэглэх заавар, БИБСЗ-өөр баталгаажуулсан Монгол хувийн хамт (батлагдсан загварын дагуу);

5.34.17. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт дэлгэмэл зураг, загвар дээж;
 5.34.19. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

- 5.35. Үндэсний үйлдвэрийн БИБ-ний бүртгэлд дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:
- 5.35.1. БИБ бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
 - 5.35.2. Эмийн хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
 - 5.35.3. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
 - 5.35.4. Генетикийн нөөц ашигласан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн батлгаажуулсан хуулбар;
 - 5.35.5. Үйлдвэрлэгч нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) эсхүл “Чанарын удирдлагын тогтолцоо”, “Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо”, “Хүнсний үйлдвэрлэлийн аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын хяналт” (ISO:9001, ISO:22000, ISO17025:2018, HACCP)-ыг нэвтрүүлсэн гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
 - 5.35.6. Үйлдвэрийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан Монгол Улсад тухайн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдлийн эх хувь;
 - 5.35.7. Үйлдвэрлэгчийн эцсийн бүтээгдэхүүнд хийсэн лабораторийн шинжилгээний дүн;
 - 5.35.8. Ажлын албатай гэрээ бүхий итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
 - 5.35.9. Ургамлын гаралтай БИБ бол ургамлын нэр, овог, зүйлийг латинаар бичиж, хийх арга болон хэлбэрийг тодорхойлсон баримт;
 - 5.35.10. Түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ, түүхий эдийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан баримт;
 - 5.35.11. Бүтээгдэхүүний орц, найрлага, аюулгүй байдлын үзүүлэлтүүд, үйлчлэл, сөрөг нөлөөний талаарх болон шинжилгээний арга, аргачлал;
 - 5.35.12. Генетикийн өөрчлөлтөд орсон орц ашигласан эсэх талаар үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
 - 5.35.13. Тухайн бүтээгдэхүүний найрлагад амьд бичил биетэн орсон бол бичил биетний овог, төрлийг латин нэрээр тодорхой зааж, хэрхэн гаргаж авсан болон бүтээгдэхүүний патентын талаарх үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
 - 5.35.14. Сэргээшийн бүлэгт багтдаг орцыг ашиглаагүй тухай үйлдвэрлэгчийн тодорхойлолт;
 - 5.35.15. БИБСЗ-өөр баталгаажуулсан БИБ-ий хэрэглэх заавар (батлагдсан загварын дагуу);
 - 5.35.16. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт зураг, загвар дээж;
 - 5.35.17. Шаардлагатай тохиолдолд гадны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний болон тээврийн төлбөрийн баримт;

4.36. Холбогдох зөвлөлийн хурлаас “бүртгэхгүй” шийдвэр гарсан эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ийн бүртгэлийн асуудлыг дахин хэлэлцүүлэхгүй. Харин хурлаас уг бүтээгдэхүүний талаар тодруулах зорилгоор хойшлуулсан тохиолдолд бүртгэлийг холбогдох зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бүртгэлийн дугаар

6.1. Эмийн бүртгэлийн дугаар нь бүртгэгдсэн эмийн эх үүсвэр, бүртгэгдсэн огноо, хүний анатомийн бүтцэд суурилсан код (АТС), эмийг олгох нөхцөл, хувийн дугаарыг агуулна.

6.2. Улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг дараах загвараар дугаарлах ба нэр томъёоны дараах товчлолыг ашиглана. Үүнд: F/T/- анх бүртгэгдсэн он, сар, өдөр-АТС-Олгох нөхцөл-тухайн эмийн дугаар (FT20161001AP00050)

	Товчлол	Тайлбар
Эх үүсвэр	F L	Foreign=Гадаад буюу импортын эм; Local=Үндэсний үйлдвэрийн эм
Зах зээлд гаргах зөвшөөрлийн хэлбэр	FT R	Fast track=Түргэвчилсэн бүртгэл Registration-Бүртгэл

	CA EUA	Conditional approval- нөхцөлт бүртгэл Emergency use approval-Яаралтай горимоор зах зээлд гаргах зөвшөөрөл
Монголд анх бүртгэгдсэн он	0000	Жишээлбэл: 2016=он
Монголд анх бүртгэгдсэн сар өдөр	0000	Жишээлбэл: 1001=10 сарын 01-ний өдөр
АТС код	A	Alimentary tract and metabolism-Хоол боловсруулах замын эмгэгт хэрэглэх эм
	B	Blood and blood forming organs-Цус, цус төлжүүлэх эрхтний эмгэгт хэрэглэх эм
	C	Cardiovascular system-Зүрх судасны тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	D	Dermatologicals- Арьсны эмгэгт хэрэглэх эм
	G	Genito urinary system and sex hormones-Шээс, бэлгийн тогтолцоо болон бэлгийн даавар
	H	Systemic hormonal preparations, excl. sex hormones and insulins-Бэлгийн даавар, инсулинаас бусад тогтолцооны дааврын бэлдмэл
	J	General antiinfective for systemic use-Нянгийн эсрэг хэрэглэх эм
	L	Antineoplastic and immunomodulating agents-Хавдрын эсрэг болон дархлаа нөлөөт бодис
	M	Musculo skeletal system-Булчин, тулгуур эрхтэний тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	N	Central nervous system-Төв мэдрэлийн тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	P	Antiparasitic products, insecticides and repellents-Паразит, шавжийн эсрэг бэлдмэл
	R	Respiratory system-Амьсгалын тогтолцооны эмгэгт хэрэглэх эм
	S	Sensory organs-Мэдрэхүйн эрхтэний эмгэгт хэрэглэх эм
	T	Traditional medicine-Уламжлалт эм
	V	Various-Эмийн түүхий эд болон бусад төрөл бүрийн бэлдмэл
Олгох нөхцөл	N Ps HO P OTC	Narcotic=мансууруулах Psychotropic=сэтгэц нөлөөт Hospital only=эмнэлгийн нөхцөлд Prescription only=жороор OTC=жоргүй
Тухайн эмийн дугаар	00000	00050; 00051; г.м 5 цифрээр

6.3. Оношлуурын бүртгэлийг дугаарлахад нэр томъёоны дараах товчлолыг ашиглана. Үүнд: F-анх бүртгэгдсэн он, сар, өдөр-шинжилгээний төрөлд суурилсан ангилал-оношлуурын дугаар (F20161001Bi00050)

	Товчлол	Тайлбар
Эх үүсвэр	F	Foreign=гадаад буюу импортын оношлуур
	L	Local=үндэсний үйлдвэрийн оношлуур
Улсын бүртгэлд анх бүртгэгдсэн он, сар, өдөр	0000-00-00	Жишээлбэл: 20161001 буюу 2016 оны 10 сарын 01

Шинжилгээний төрөлд суурилсан ангилал	Bi Cc He Im Ih Mb Mi Pt O	Bi -Biochemistry-Биохими Cc -Clinical chemistry-Клиникийн хими He - Hematology-Гематологи Im - Immunology -Иммунологи Ih -Immunohematology-Иммуногематологи Mb -Molecular biology-Молекулбиологи Mi -Microbiology-Микробиологи Pt -Pathology-Патологи O -Other-Бусад
	PO	Pharmacy only-Зөвхөн эмийн сангаас олгох бүтээгдэхүүн
	HO	Hospital only=эмнэлгийн нөхцөлд
Тухайн оношлуурын дугаар	00000	00050; 00051; г.м 5 цифрээр

6.4. БИБ-ний бүртгэлийн дугаар нь тухайн БИБ-ний эх үүсвэр, Монгол Улсад бүртгэгдсэн огноо, үсгэн тэмдэглэгээ, БИБ-ний хувийн дугаарыг агуулна.

6.5. Бүртгэлд бүртгэгдсэн БИБ-нд бүртгэлийн дугаар олгохдоо нэр томъёоны дараах товчлолыг ашиглана. Үүнд: F-анх бүртгэгдсэн он, сар, өдөр-Үсгэн товчлол-бүтээгдэхүүний дугаар (F20161001Supp00050)

	Товчлол	Тайлбар
Эх үүсвэр	F L	Foreign=Гадаад буюу импортын БИБ; Local=Үндэсний үйлдвэрийн БИБ;
Улсын бүртгэлд анх бүртгэгдсэн он, сар, өдөр	0000-00-00	Жишээлбэл: 201601001 буюу 2016 оны 10 сарын 01
Үсгэн тэмдэглэл	Supp	Supplement-Биологийн идэвхт бүтээгдэхүүн
Олгох нөхцөл	PO	Зөвхөн эмийн сангаас олгох бүтээгдэхүүн
Тухайн БИБ-ний дугаар	00000	00050; 00051; г.м 5 цифрээр

6.6. Бүртгэлийн гэрчилгээг нэг хувь үйлдэж, бүртгүүлэгч байгууллагад олгох ба хуулбарыг нь ажлын алба архивлана.

6.7. Эмийн бүртгэлийн гэрчилгээнд ХЭЗ-ийн дарга, оношлуурын бүртгэлийн гэрчилгээнд БОСЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ХЭЗ-ийн дарга, БИБ-нийн бүртгэлийн гэрчилгээнд БИБСЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ХЭЗ-ийн дарга гарын үсэг зурж, ЭМЯ-ны тэмдгээр баталгаажуулна.

Долоо. Бүртгэлийн хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох

7.1. Тухайн эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ийг анх бүртгүүлсэн байгууллага бүртгэлийн өөрчлөлт, хугацаа сунгуулахтай холбоотой үйлдвэрлэгчээс ирүүлсэн баримт бичиг, албан хүсэлтийг ажлын албанд хүлээлгэн өгнө.

7.2. Эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ бүртгүүлэгч бүртгэлийн хүчинтэй хугацаа дуусахаас зургаан сарын өмнө хугацаа сунгуулах хүсэлтийг гаргана.

7.3. Эмийн чанар, аюулгүй байдал, эмчилгээний идэвх, зар сурталчилгаатай холбоотой тайлан, хяналт, шалгалтын дүн, холбогдох дүгнэлтийг Эмийн аюулгүй байдал, тандалт судалгаа болон Чанарын хяналтын асуудал хариуцсан нэгжээс авна.

7.4. Эмийн бүртгэлийн хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

7.4.1. Бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;

- 7.4.2. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 7.4.3. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн эм, эмийн түүхий эдийн хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;
- 7.4.4. ДЭМБ-ын жишгийн дагуу эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан эмийн бүтээгдэхүүний сертификатын эх хувь эсхүл албан ёсоор баталгаажуулсан хувь (эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 7.4.5. Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 7.4.6. Хугацаа дуусах бүртгэлийн гэрчилгээний эх хувь;
- 7.4.7. Ажлын албатай гэрээтэй итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;
- 7.4.8. Зах зээлийн дараах эмийн аюулгүй байдлын лавлагаа;
- 7.4.9. Эмийн бүртгэлд өөрчлөлт орсон бол орсон бүх өөрчлөлтийн талаарх мэдээлэл;
- 7.4.10. Эм судлалын салбар зөвлөлөөр баталгаажуулсан хэрэглэх зааврын хувь (эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 7.4.11. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт загвар зураг (эмийг олгох нөхцөл, бүртгэлийн дугаар бичих талбарыг заасан байх, эмийн түүхий эдэд хамаарахгүй);
- 7.4.12. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зохистой байдлын лавлагаа (зөвхөн жоргүй олгох эмэнд хамаарна).

7.5. Оношлуурын бүртгэлийн хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 7.5.1. Оношлуур бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
- 7.5.2. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 7.5.3. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн оношлуурын хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;
- 7.5.4. Хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 7.5.5. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 7.5.6. Үйлдвэрлэгчийн чанарын удирдлагын тогтолцооны гэрчилгээ (ISO13485)-ний хуулбар (үйлдвэрлэгч баталгаажуулсан байх);
- 7.5.7. Хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний эх хувь эсхүл үйлдвэрлэгчээс баталгаажуулсан хуулбар хувь;
- 7.5.8. Оношлуурыг шинжилсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, загвар дээжийг туршсан дүнгүүд;
- 7.5.9. Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны асуудал хариуцсан нэгжээр хянуулсан зах зээлийн дараах тандалт судалгааны дүн;
- 7.5.10. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан хэрэглэх заавар (БОСЗ-өөр баталгаажуулсан байх);
- 7.5.11. Анхдагч болон хоёрдогч савлалт (анх бүртгүүлсэн болон одоогийн)-ын өнгөт загвар зураг;
- 7.5.12. Оношлуурын бүртгэлд өөрчлөлт орсон бол орсон бүх өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

7.6. БИБ-ний хугацааг сунгуулахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- 7.6.1. БИБ бүртгүүлэгч байгууллагын албан хүсэлт;
- 7.6.2. Бүртгэлийн хугацааг сунгуулах тухай үйлдвэрлэгчийн албан хүсэлт;
- 7.6.3. Үйлдвэрлэгчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, тухайн БИБ-ий хугацааг сунгуулах өргөдлийн эх хувь;
- 7.6.4. Хэрэглээний явцад гарах чанар, аюулгүй байдлын баталгааны дүгнэлт;
- 7.6.5. Зах зээлийн дараах тандалт судалгаа хийх ажлын төлөвлөгөө;
- 7.6.6. Үйлдвэрлэгч нь эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) эсхүл “Чанарын удирдлагын тогтолцоо”, “Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо”, “Хүнсний үйлдвэрлэлийн аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын хяналт” (ISO:9001, ISO:22000, ISO17025:2018, HACCP)-ыг нэвтрүүлсэн гэрчилгээ (үйлдвэрлэгчийн баталгаажуулсан хуулбар);
- 7.6.7. Хугацаа дууссан бүртгэлийн гэрчилгээний эх хувь эсхүл үйлдвэрлэгчээс баталгаажуулсан хуулбар хувь;
- 7.6.8. Эмийн бүртгэлийн хэлтэстэй гэрээтэй итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн;

- 7.6.9. Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны асуудал хариуцсан нэгжээр хянуулсан зах зээлийн дараах тандалт судалгааны дүн;
- 7.6.10. БИБ-ний хэрэглэх заавар (БИБСЗ-өөр баталгаажуулсан байх);
- 7.6.11. Анхдагч болон хоёрдогч савлалтын өнгөт загвар зураг;
